


БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ИНЧОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС





209.38 км²

Инчоны эдийн засгийн чөлөөт бүсийг 2003 оны 8-р сард Солонгосын засгийн газар албан ёсоор нээсэн. Солонгосын засгийн газраас агаарын болон далайн тээвэр, ложистикийн цогцолбор, олон улсын бизнесийн төв, санхүүгийн үйлчилгээ, орон сууц, сургууль эмнэлэг, худалдаа, үзвэр үйлчилгээний төвүүд бүхий бие даасан бизнесийн дүүрэг байхаар төлөвлөсөн.

ИНЧОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗОРИЛГО

Сонгдо, Чонгна, Ёнжонг бүсийг Зүүн хойд Азийн бүс нутгийн ложистик, олон улсын бизнес, амралт чөлөөт цаг, аялал жуулчлалын төв болгох явдал юм.



Инчоны эдийн засгийн чөлөөт бүс нь ирээдүйд дэлхийн хамгийн том гурван эдийн засгийн бүсийн нэг болох зорилготойгоор байгуулагдсан.

- Дэд бүтцийн хөгжлийн үе шат 2003 – 2009 он
- Төсөл боловсруулах үе шат 2010 – 2014 он
- Эцсийн шатыг 2020 он гэхэд дуусгахаар төлөвлөсөн.

Анх 2003 онд Инчоны чөлөөт бүсийг хөдөлгөөн ихтэй онгоцны буудал болон далайн боомтыг түшиглэн нээж байсан бол түүнээс хойш 9 эдийн засгийн чөлөөт бүсийг орон нутгийн онцлог бүрт тохируулан хөгжүүлж байна.

2018 оны байдлаар:



5250

Компани үйл
ажиллагаа явуулж
байна.



178

тэрбум
Шууд хөрөнгө
оруулалт татсан.

Ази тивийн анхны **НОГООН БҮС**



Тус бүс нь газарзүйн давуу талаа ашиглан 156 хотод 3 цагийн дотор нэгэн зэрэг хүрэх боломжтой бөгөөд хурдацтай хөгжиж буй Зүүн хойд Азийн эдийн засгийн гол тулах цэг болж байна.

ИНЧОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ОНЦЛОГ

Дэлхийн хамгийн шилдэг Био-анагаахын хотыг барьж байгуулж байгаа бөгөөд энэ хот нь хамгийн орчин үеийн техник технологийг тэргүүлэгч болон хөгжиж байна.

- Ухаалаг хот
- Эрүүл аюулгүй хот
- Нүүрстөрөгч зарцуулдаггүй эрчим хүчний хот
- Шинэ газар нутаг, шинэ хот

